

**ШУУРХАЙ ХЯНАЛТЫН ТӨВИЙН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ АЛТАНСАНГИЙН ЭРХБАЯРЫН
2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. "УЛСЫН ХИЛЭЭР ХУУЛЬ БУСААР БАРАА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ НЭВТРҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ"								
1.	Теле хяналтын нэгдсэн систем, камерын хэвийн, найдвартай, аюулгүй байдлыг ханган ажилласан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90%	100%	01-12 дугаар саруудад нэгжийн даргын баталсан хуваарын дагуу телехяналт хийх газар, хорооны телехяналтын камерын хэвийн ажиллагааг шалгаж, тасарсан тохиолдолд тухайн гаалийн газар, хорооны хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч нарт мэдэгдэн, холбогдохгүй байгаа шалтгаан нөхцөлийг тодруулах телехяналтын камеруудын хэвийн ажиллагааг хангаж ажиллахыг цаг тухай бүрт нь мэдэгдэж ажилласан. Цаашлаад нэгжийн даргын баталсан "Гаалийн газар хорооны телехяналтын нэгдсэн системийг хариуцах ГУБ нарын хуваарь"-ийн дагуу ГУБ Ш. Батболдын хамтаар УБГГ, ШХГГ, УвГГ, ОрГГ, ЧХОУНБГГ болон БигГ-ын телехяналтын дэд систем, камерын хэвийн найдвартай аюулгүй байдалд хяналт тавин, тухайн гаалийн газар хорооны МТ хариуцсан ГУБ нарт мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэн, хамтарч ажилласан. 2024.02.07-ны өдөр харьяа гаалийн газар хороодод телехяналтын дэд төвүүдийн системийн хэвийн найдвартай ажиллагаа, арчилгаа үйлчилгээ, ашиглалтын байдлыг сайжруулах, 2023 оны "Хяналтын нэгдсэн төвийн үйл ажиллагааны заавар батлах тухай" А/248 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 2024.02.07-ны өдрийн 01-5/495 дугаартай албан бичгээр, харьяа гаалийн газар хороодод телехяналтын дэд системийн ашиглалтын мэдээг хавсралтаар хүргүүлсэн загварын дагуу гарган, сар бүрийн эхний 7 хоногт багтаан ЗДАС-т байршуулж байх чиглэлийг 2024.03.25-ны өдрийн 01-2.2/1129 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.	2024.01.02-2024.11.30	100%	

					<p>2024 оны 10 дугаар сард харьяа гаалийн газар, хороодод хүргүүлэх ЗДАС-ийн үүрэг даалгаврын цэсээр дамжуулан дараах үүрэг даалгаврыг хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажилласан. Үүнд:</p> <p>1. Харьяа гаалийн газар хороодын дарга, салбарын эрхлэгч нар телехяналтын дэд систем, телекамер, техник тоног төхөөрөмж болон бусад дагалдах хэрэгслүүдийн хэвийн үйл ажиллагааг ханган, түүхчилсэн бүртгэлийг тасралтгүй хөтлөн, телекамерын хяналтыг гаалийн хяналт бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд тогтмол ашиглаж, телехяналтын дэд системийн ашиглалтын мэдээг загвар хүснэгтийн дагуу сар бүр гарган, Захиргаа, дотоод ажлын системийн "Мэдээ, мэдээлэл" талбарт байрших нэгжийг "Шуурхай хяналтын төв"-ийг сонгон, дараа сарын эхний 7 хоног багтаан тогтмол байршуулж ажиллах</p> <p>ГЕГ-ын дэргэдэх Бүрдүүлэлтийн цахим төвд суурилуулах телекамерын байршил, тоо ширхэг болон дагалдах тоног төхөөрөмжийн техник үзүүлэлтийн судалгааг гарган шаардлагатай тоног төхөөрөмж, програм хангамжийн судалгаа, техник үзүүлэлтийг БХ, СХОГ-т тус тус хүргүүлсний дагуу худалдан авах ажиллагаа нээлттэй тендер шалгаруулалт хийх үнэлгээний хороонд нарийн бичгээр ажиллаж, тендерийн бичиг баримтыг боловсруулан батлуулж, 3 удаагийн тендерийг зохион байгуулж, нийлүүлэгчийн шалгаруулсан. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй 2024 оны 11 сарын 28 өдрийн тоот телехяналтын тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах гэрээ байгуулсан. Уг гэрээний дагуу 52 ширхэг телехяналтын камер, дагалдах тоног төхөөрөмж /сервер-2, хард диск- 8, лиценз-62/нийлүүлж угсралт,суурилуулалт, холболтын ажил хийгдэж бүрэн дууссан. Гэрээний хэрэгжилтийг дүгнэх, ажил хүлээлцэн авах ажлыг хэсгийн тушаалын дагуу ажлын хэсэг ажиллаж байна.</p>		
2.	Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн чиглэлээр ашиглагдах бүх төрлийн мэдээллийг төрөлжүүлэн	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	92%	100%	Гаалийн хяналт бүрдүүлэлтэд шаардлагатай бүхий л төрлийн мэдээллийг цуглуулах, тэдгээрт дүн шинжилгээ хийж, холбогдох нэгжийг мэдээ мэдээллээр хангах нөхцөл боломжийг хангах үүднээс 2024 онд:	2024.01.02-2024.11.30	100%

<p>цуглуулж, сан үүсгэх, дүн шинжилгээ хийсэн байдал</p>			<ul style="list-style-type: none"> - Зөвлөмжийн дагуу илрүүлсэн зөрчилд холбогдсон хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийн сан, - Улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн орсон гарсан бүртгэлийн сан болон манифестийн сан, - Ухаалаг гарцын тээврийн санд дүн шинжилгээ хийн, мөн цаг үеийн байдлаар - ЗҮГГ түүвэр ачааны судалгаа /8-р сар/, - ЗҮ боомтоор импортолсон хүнсний ногоо, жимсний судалгаа /6, 9-р сар/, - ЗҮ боомтоос УБГГ-ын гаалийн хяналтын бүсэд илгээгдэж буй ачааны судалгаа /11-р сар/, - Шалгуурын судалгаа /I болон II-р хагас жилд/, - Зөвлөмжийн судалгааг /I болон бүтэн жилээр/ тус тус хийн, <p>судалгааны үр дүнг өдөр тутмын үйл ажиллагаа болон эрсдэл тооцоход ашиглан, холбогдох нэгжийг мэдээ мэдээллээр ханган ажилласан.</p> <p>Эрсдэлийн шалгуурын үзүүлэлтийн хүсэлтийн хүрээнд Tableau дата платформд шалгуурын дагуу Шуурхай хяналтын төвөөс илгээсэн зөвлөмжийн хүрээнд илэрсэн зөрчилд холбогдсон ААН, итгэмжлэгдсэн төлөөлөгч, барааны нэр төрөлд хийсэн дүн шинжилгээнд боловсруулсан эрсдэлтэй ААН болон барааны мэдээллийг ЭУХ-т дотоод зурвасаар 3 удаа хүргүүлсэн.</p> <p>Төсвийн орлогыг бүрдүүлэх төлөвлөгөөний хүрээнд боомтоор нэвтэрч байгаа ачаатай тээврийн хэрэгслийн тоо, гүний гаалийн хяналтад илгээсэн тээврийн хэрэгслийн тоо, ачаатай тээврийн хэрэгсэл рентген хяналтад орсон мэдээг 7 хоног бүр гарган, ТОГ-т тогтмол хүргүүлэн ажилласан.</p> <p>Зөвлөмжийн програмд ажиллаж буй шалгуур үзүүлэлтүүдэд бууж буй эрсдэлтэй мэдүүлгийн тоонд дүн шинжилгээ хийн, шалгуур үзүүлэлтүүдийн оновчтой байгаа эсэхийг тодорхойлж, санал боловсруулж, Табью платформд ГУБ Б.Дөлгөөний хамтаар шалгуур нэмж ажилласан.</p> <p>ЗҮ боомтоос УБГГ-ын харьяа хяналтын бүсэд илгээгдэж буй ачаа тээврийн судалгааг хийж, цаашид Замын-Үүд боомтын ачааллыг бууруулах, гаалийн хяналт шалгалтыг сайжруулах</p>		
--	--	--	---	--	--

					чиглэлээр судалгаанд үндэслэн, саналыг боловсруулж дэд даргад танилцуулсан.		
3.	Мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан онилгоо хийн, зөвлөмж илгээсэн байдал	Хэрэгжилт, хувиар	91.4%	100%	Тайлант хугацаанд телехяналтын камер, таблью дата аналитикийн платформыг ашиглан эрсдэлтэй барааны шалгуурт гарж ирсэн мэдүүлэгт дүн шинжилгээ хийн, эрсдэлтэй гаалийн мэдүүлэгт КАИС-аас зөвлөмж илгээх үйл ажиллагааны хүрээнд нэгжийн нийт ГУБ нарыг удирдлагаар ханган ажилласан. ШХТ-өөс илгээсэн 112 зөвлөмжийн дагуу ХШГУБ биет үзлэг хийн 87 зөрчил илрүүлж 482.6 сая.төг-ийн татварыг нөхөн төлүүлж, 249.38 сая.төг-ийн торгууль ногдуулан зөрчлийг арилгаж ажилласан байна.	2024.01.02-2024.11.30	100%
4.	Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд тавьсан хяналт, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлсэн байдал, аюулгүй байдлыг хангахад хамтран ажилласан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	95%	100%	1. CAIS-д мэдүүлсэн бараа тээврийн хэрэгслийн өгөгдлийг Таблью дата аналитик платформ ашиглан, бодит цагаар боловсруулан сонгогдсон эрсдэлтэй гаалийн мэдүүлэгт Телехяналтын нэгдсэн систем болон рентген тоног төхөөрөмж, ухаалаг гарц, дугаар таних системд хүлээн авсан мэдээлэлд давхар дүн шинжилгээ хийн, эрсдэл тооцож 2023 оны ГЕГ-ын даргын А/248 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Хяналтын нэгдсэн төвийн үйл ажиллагааны зааврын дагуу CAIS-ийн онилгооны програмаар тайлант хугацаанд 112 зөвлөмжийг гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд илгээсэн байна. Үүнээс: 87 буюу 77.68%-д нь татвараас зайлсхийсэн болон зайлсхийхийг завдсан зөрчлүүдийг тус тус илрүүлж, таслан зогсоосон байна. ББГУБ, ХШГУБ, ГЗТХБА ГУБ-д илгээсэн зөвлөмжийн дагуу илрүүлсэн зөрчлийн тоо өмнөх оны мөн үеэс 40% орчим хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2. 2024 оны 03 дугаар сард Зорчигчийн мэдээллийн төвтэй Эрсдэлийн удирдлагын хэлтэс болон Шуурхай хяналтын төв хамтарсан уулзалт хийн, цаашид үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, эрсдэл бүхий зорчигчийн мэдээлэл солилцох, хил дамнасан мөнгө угаах гэмт хэргийн харилцан хамааралтай талуудыг таньж тогтоох, худалдааны луйвар илрүүлэх болон мэдээлэл солилцох чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцсон. Мөн тус уулзалтаар APIS-аас	2024.01.02-2024.11.30	100%

					<p>авдаг зорчигчийн мэдээллүүдээр нэмэлтээр тухайн зорчигчийн тээшинд өгсөн ачааны тоо, зорчигчийн аялалын дэлгэрэнгүй маршрут огноо, цагаар мэдээллийг солилцох саналыг дэвшүүлсэн. Зөрчилтэй тэмцэх газраар дамжуулан бусад хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу бичлэгийг баримтжуулан хуулбарлаж, хүргүүлэн хууль сахиулах ажиллагаанд туслан дэмжиж ажилласан байна. (Бусад төрийн байгууллагатай хууль сахиулах чиглэлээр үр дүнтэй хамтран ажилласан байдал)</p> <p>3. Батлагдсан хуваарийн дагуу телехяналт тавихдаа тухайн гаалийн байгууллагын барилга байгууламж, албан хаагчдын аюулгүй байдалд эрсдэл учирч болзошгүй нөхцөл байдалд эрсдэл тооцон ажилласан. ХОГГ-ын Булган боомт дахь үндсэн байгууламж руу хардаг телекамер шуурганд унасан байсныг олж тогтоон, тус газарт албан утсаар мэдэгдэн буцаан байршуулан тогтоосон.</p>		
5.	Гаалийн байгууллагатай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	100%	<p>Иргэд олон нийттэй харилцах ЗГ 11-11 төвөөр дамжуулан гаалийн байгууллагад ирсэн гомдол санал хүсэлтийг хүлээн авч бүртгэх, холбогдох нэгж рүү нь шилжүүлэх, шийдвэрлүүлэх, ГЕГ-ын удирдлагыг 7 хоногийн мэдээллээр хангах ажлын хүрээнд 2024 оны 05 дугаар сард түр хариуцан ажилласан. Ажиллах хугацаанд хууль тогтоомжийн хүрээнд гомдол саналыг ЗГ 11-11 төвийн програмаар хүлээн авч, гаалийн байгууллагын ЗДАС-ийн "Дуудлага төв" цэсэнд бүртгэлжүүлэн, холбогдох нэгж рүү нь цахимаар шилжүүлж, утсаар мэдэгдэн, шийдвэрлэлтийн хугацаанд хяналт тавин ажилласан.</p> <p>АТГ-аас ГЕГ-т хүргүүлсэн зөвлөмжийн хүрээнд Гаалийн лавлах 1800-1281 тусгай дугаарыг иргэн хуулийн этгээдэд ЗУГ, ОНХ нэгжтэй хамтран сурталчилан таниулах /шторк хийх/ ажлыг хамтран зохион байгуулсан.</p> <p>Гаалийн лавлах 1800-1281, ЗГ 11-11 төв, Бүрдүүлэлтийн цахим төвд 2023 оны сүүлийн хагас жил болон 2024 оны эхний хагас жилд ирсэн дуудлага, санал, гомдолд дүн шинжилгээ хийн, төрөлжүүлэн ангилж, Гаалийн хяналт, бүрдүүлэлт, Хорио цээр, Мэдээлэл технологийн саатал, гэмтэлтэй холбоотой</p>	2024.01.02-2024.11.30	100%

					<p>асуултуудын давтамжийг тодорхойлж, тогтмол асуугддаг асуултуудын жагсаалтыг гарган, холбогдох нэгжээс нэгдсэн байдлаар хариуг дотоод зурвас хүргүүлэн авч, кодчилон ЗДАС Дуудлагын төв цэсэнд "Гарын авлага" цэсний хөгжүүлэлт хийх өгөгдлийг бэлтгэсэн. Ингэснээр гаалийн лавлах 1800-1281-ийн оператор болон ажиллах гаалийн зөвлөхүүд иргэд олон нийтэд гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг шуурхай өгөх нөхцөл боломжоор хангагдсан.</p> <p>Гаалийн лавлах 1800-1281, ЗГ 11-11 төв, Бүрдүүлэлтийн цахим төвд 2024 оны эхний хагас жил, 2024 онд жилийн эцсийн байдлаар /өссөн дүнгээр/ ирсэн дуудлага, санал, гомдолд дүн шинжилгээ хийн, Гаалийн хяналт бүрдүүлэлт болон гаалийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол мэдээлэлд хийсэн дүн шинжилгээний тайлан мэдээг ЗУГ-т 2 удаа хүргүүлсэн.</p>		
6.	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	100%	ЗДАС-ын Үүрэг даалгаврын цэсэнд ЗУГ-аас 4 үүрэг даалгавар, 1 Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, ХШУДАГ-аас 3 зөвлөмж, ЭУХ-с 1 онлайн хурлын даалгавар, 1 Ёс зүйн дэд хорооны хуралдаан, 1 үүрэг даалгавар ирсний хэрэгжилтийг бүрэн ханган, биелэлтийг цаг тухайд нь оруулсан.	2024.01.02-2024.11.30	100%
7.	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	100%	Цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид тогтмол бүртгүүлж ажилласан. Чөлөөтэй, өвчтэй, тасалсан тохиолдол байхгүй. Гадуур болох хурал зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох болон ээлжийн амралтыг ЗДАС программд хүсэлт илгээн нэгжийн даргаар батлуулсан. Ажлын цаг ашиглалтыг үр дүнтэй, гүйцэтгэл сайтайгаар ажилласан.	2024.01.02-2024.11.30	100%
Зорилт 2. "ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ"							
1.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	100%	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд СЭГГ-ын Алтанбулаг чөлөөт бүсийг телехяналтын нэгдсэн системд холбуулах ажлыг зохион байгуулах албан шаардлагыг 01-2.2/2299 дугаартай албан бичгээр СЭГГ-т хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого, шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 02 дугаартай хуралдааны шийдвэрийн хэрэгжилт, АТГ-аас Гаалийн	2024.01.02-2024.11.30	100%

					ерөнхий газарт ирүүлсэн зөвлөмжийн биелэлт I болон II хагас жилээр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлтийг I болон II хагас жилээр тус тус тайлагнан, ЗУГ-т хүргүүлсэн.		
2.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	100%	Нэгжийн чиг үүрэгт хамаарах хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажилласан. Сангийн яамны 2022_16 дугаартай Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай шийдвэрийн 01-11 дүгээр сарын хэрэгжилтийг тогтоосон хугацаанд нь ГУБ Б. Болдбаярын хамтаар сар бүр тайлагнаж Хуулийн хэлтэст хүргүүлж ажилласан байна. Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг хагас болон бүтэн жилээр тайлагнаж, Хуулийн хэлтэст хүргүүлсэн.	2024.01.02-2024.11.30	100%
3.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	100%	ЭУХ болон ХШҮДАГ-ийн хамтарсан 2 удаагийн сургалтад хамрагдаж, нэгжийн нийт албан хаагчдад дотооддоо мэдээллийг хүргэн, нэгжийн дотоод эрсдэлийн таньж тогтоон, бууруулах ажлыг төлөвлөх зорилгоор 3 удаагийн хурал хийж, ГЕГ-ын даргын 2022.12.14-ны өдрийн А/342 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх" журмын 5.7.2-5.7.4 дэх хэсэгт заасны дагуу эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийн давтамж, үр дагаварын үржвэрээр эрсдэлийн матрицаа гаргаж, эрсдэлийн түвшинг тодорхойлсон. Эрсдэлийн түвшинг тус журмын 5.8-д заасан итгэлцүүрийн үржвэрээр үржүүлж эрсдэлийн нийт үнэлгээг гаргаж, эрсдэлийн түвшингээр эрэмбэлэн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө гарган ажилласан. 2024 оны эхний хагас жилд 8, сүүлийн хагас жилд 12 эрсдэлийг таньж тогтоон, үнэлэн ажилласан. Дээрх 20 эрсдэлээс 5-аас дээш өндөр эрсдэлтэйд тооцогдох нийт 5 эрсдэл байсан ба эдгээрийг бууруулах чиглэлээр тодорхой ажлуудыг хийж өндөр эрсдэлийн түвшинг бууруулж ажилласан. Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдлын биелэлтийг тайлагнасан.	2024.01.02-2024.11.30	100%
4.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй ажил	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	100%	2009 оны 169 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн лавлах 1281"-ийн үйл ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулахад өөрийн саналыг тусгаж, Мэргэжлийн хуралдаанд хэлэлцүүлэх танилцуулгыг бэлтгэн танилцуулж, батлуулсан.	2024.01.02-2024.11.30	100%

					<p>Цаг үеийн шинжтэй бусад ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд: ГЕГ-ын даргын "Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал"-ыг батлах тухай А/238 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтэд оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг боловсруулан ХШҮДАГ-т хүргүүлсэн.</p> <p>Сангийн сайдын 2024 оны 06 дугаар тушаалаар нэгжийн чиг үүрэг шинэчлэгдсэнтэй холбогдуулан Шуурхай хяналтын төвийн болон харьяа газар, хороодын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг ХНХ-т хүргүүлсэн.</p> <p>ДГБ-аас гишүүн орнуудаас авсан Targeting center-н үйл ажиллагааны судалгааг бөглөн, хүргүүлсэн.</p> <p>2024 оны улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх шуурхай ажлын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж, ТОГ-т хугацаанд нь тайлагнасан.</p> <p>ГЕГ-ын дэргэдэх Бүрдүүлэлтийн цахим төвд суурилуулах телекамерын байршил, тоо ширхэг болон дагалдах тоног төхөөрөмжийн техник үзүүлэлтийн судалгааг гарган шаардлагатай тоног төхөөрөмж, програм хангамжийн судалгаа, техник үзүүлэлтийг БХ, СХОГ-т тус тус хүргүүлсний дагуу худалдан авах ажиллагаа нээлттэй тендер шалгаруулалт хийх үнэлгээний хороонд нарийн бичгээр ажиллаж, тендерийн бичиг баримтыг боловсруулан батлуулж, 3 удаагийн тендерийг зохион байгуулж, нийлүүлэгчийн шалгаруулсан. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй 2024 оны 11 сарын 28 өдрийн тоот телехяналтын тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах гэрээ байгуулсан. Уг гэрээний дагуу 52 ширхэг телехяналтын камер, дагалдах тоног төхөөрөмж /сервер-2, хард диск- 8, лиценз-62/нийлүүлж угсралт,суурилуулалт, холболтын ажил хийгдэж бүрэн дууссан. Гэрээний хэрэгжилтийг дүгнэх, ажил хүлээлцэн авах ажлыг хэсгийн тушаалын дагуу ажлын хэсэг ажиллаж байна.</p>		
5.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй ажил	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	100%	Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Гаалийн лавлах 1800-1281,	2024.01.02-2024.11.30	100%


					ЗГ 11-11, Цахим бүрдүүлэлтийн төвд иргэд, олон нийтээс Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд хагас жил болон бүтэн жилээр дүн шинжилгээ хийж тайланг ЗУГ-т 2 удаа хүргүүлэн ажилласан. Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тайланг ЗУГ-т 2 хүргүүлсэн.		
--	--	--	--	--	---	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5		6	7
1	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Дотоодын хэргийн их сургуулийн эрх зүйн бакалаврын сургалтыг амжилттай дүүргэж төгссөн.	ДГБ-ын CLiKC E-learning цахим сургалтад хамрагдсан байна.	Сургалтын төвөөс зохион байгуулсан VR 4 цагийн сургалтад 2024 оны 01-р сард хамрагдсан. Худалдан авах ажиллагааны АЗ сертификатны 3 хоногийн сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн		2024.01.02-2024.11.30	100%
2	Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Англи хэл бие даан сурч, хэлний зохих түвшиний мэдлэгтэй болсон.	Гаалийн хэрэг, гадаад худалдаатай холбогдолтой англи хэлний үгсийн санг нэмэгдүүлэх	TRAM төслөөс боловсруулсан Худалдааг хөнгөвчлөх нэр томъёоны тодорхойлолт гарын авлага болох Англи Монгол тайлбарыг судалж, мэдлэгээ дээшлүүлсэн.		2024.01.02-2024.11.30	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гаалийн улсын ахлах байцаагч
(Албан тушаал)

А. Эрхбаяр /  /
(Нэр, гарын үсэг)

2024 оны 12 дугаар сарын 10
(Огноо)

581

**ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ А.ЭРХБАЯРЫН 2024 ОНЫ АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ
ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Шуурхай хяналтын төв

1.ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	

Зорилт 2. “Улсын хилээр хууль бусаар бараа тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх”

1.	Теле хяналтын нэгдсэн систем, камерын хэвийн, найдвартай, аюулгүй байдлыг ханган ажилласан байдал	45	7	52	
2.	Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн чиглэлээр ашиглагдах бүх төрлийн мэдээллийг төрөлжүүлэн цуглуулж, сан үүсгэх, дүн шинжилгээ хийсэн байдал	55	8	63	
3.	Мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан онилгоо хийн, зөвлөмж илгээсэн байдал	60	8	68	
4.	Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд тавьсан хяналт, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлсэн байдал, аюулгүй байдлыг хангахад хамтран ажилласан байдал	60	8	68	
5.	Гаалийн байгууллагатай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлүүлсэн байдал	60	10	70	
6.	Үүрэг даалгаврын биелэлт	55	8	63	
7.	Ажлын цаг ашиглалт	55	8	63	

Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”

1.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	60	10	70	
2.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	60	10	70	
3.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	55	8	63	
4.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	60	10	70	
5.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	60	10	70	
Дундаж оноо:				65	

2.МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
1.	1. Гадаад болон дотоодын байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдах	100%	15	
2.	2. Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх	100%	15	
Дундаж оноо:			15	

3.ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	7	
3.	Асуудал шийдвэрлэх	7	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6	Мэргэжлийн ур чадвар 1.	7	
Дундаж оноо:		7	

4.ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)

	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо: 8		

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (<i>Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно</i>)	(65.83 оноо)
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 оноо)
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (<i>Нэгжийн даргын үнэлгээ</i>)	(7 оноо)
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (<i>Хамт олны үнэлгээ</i>)	(8 оноо)
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (<i>Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих</i>)	
Нийт оноо =		95.83
(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (<i>Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ</i>)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Шуурхай хяналтын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



.....

И.Ц. Хатанболд/
2024.12.10
..... (оноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

Шуурхай хяналтын төвийн гаалийн улсын ахлах байцаагч


.....

И.А. Эрхбаяр/
2024/10
..... (оноо)

Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч



/Г. Энхтайван/

2024.12.20 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн
Гаалийн улсын ахлах байцаагч




/Ө. Тэгшээ/

2024.12.20 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч
Гаалийн ерөнхий газрын дарга



/Р. Отгонжаргал/

(огноо)